



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/180

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан “Зоон давааны орчинд хамгаалалтын ойн зурвас байгуулах” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу дээрх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр Улаанбаатар хотын “Ойн хайгуул” ХХК-ийг сонгож 38 373 958 /гучин найман сая гурван зуун далан гурван мянга есөн зуун тавин найм/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.


2. Дээрх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Ойн хайгуул” ХХК /Д.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.

4. Гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд “Ойн хайгуул” ХХК нь ирүүлсэн саналын дагуу орон нутгийн ажилгүй иргэдээс 10 ажиллах хүч ажиллуулж буй эсэхэд хяналт тавихыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар /Н.Батжаргал/-д даалгасугай.

5. Тус ажлыг хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

D disk /toot/

20190179